



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/12.

Улаанбаатар хот

### Сар шинийн баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл ажиллуулах тухай

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газрын "Дүрэм"-ийн 2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны 2 дугаар сарын 18-наас 22-ны өдрийг хүртэл сар шинийн баярын өдрүүдэд тус газрын эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлаар шуурхай шийдвэрлэх нөхцөл байдал үүссэн үед газрын дарга, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллах хариуцлагатай жижүүрт мэдэгдэж, хариуцлагатай эргүүлээр ажиллахыг мэдээлэл сурталчилгааны төв хариуцсан менежер /Д.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

2. Хариуцлагатай эргүүлийн ажилд хяналт тавьж ажиллахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д даалгасугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА

УОА0453